



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 09/02

Эрдэнэт

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7, 20.1.9, 20.1.18, 20.1.21, 20.1.22, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.15 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:


1.Эрдэнэт хотын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, аймгийн Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн Засаг дарга С.Батжаргалд ДААЛГАХ нь:

2.1.Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж ажиллуулах.

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, явцын талаарх мэдээллийг 2022 оны 08 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
05 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит IX хуралдааны
09/02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ЭРДЭНЭТ ХОТЫН 2022-2023 ОНД ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
"ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖИЛ"-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зохион байгуулж, хэрэгжүүлэх байгууллага	Төсөвт өртөг (төгрөг)	Хөрөнгийн эх үүсвэр (тайлбар)
Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлууд					
1	Өмнөд дэд станцын өргөтгөл 35/6кВ-ын 2x10000 чадалтай дэд станц барих	II-IY улирал	ХББ3А, "ЭБЦТС" ТӨХК	2,535,500,000	Орон нутгийн төсөв
2	Уртын гол баг. Ус дулаан түгээх төв " Уртын гол баг-1" барих ажил	II-IY улирал	Х3А, ХББ3А, "ЭУДТС" ОНӨХК	540,173,400	Орон нутгийн төсөв
3	Жаргалант сумын дулааны станцын зураг төсөлд тусгагдаагүй ажлыг хийж гүйцэтгэх	II-IY улирал	Х3А, ХББ3А, "ЭУДТС" ОНӨХК Жаргалант ЗДТГ	87,690,000	Орон нутгийн төсөв- 87 сая төгрөг Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй
4	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар үргэлжлүүлэн хийх, зайлшгүй шаардлагатай шугам сүлжээний шинэчлэлтийн ажил /12 ажил/	II-III улирал	ХББ3А, Баян-Өндөр, Жаргалант сум	4,014,183,500	Орон нутгийн төсөв, Баян-Өндөр, Жаргалант сумдын хөрөнгө оруулалт
5	Орон сууцны хорооллын цахилгаан эрчим хүчний найдвартай байдлыг хангах (5 ажил)	II-III улирал	ХББ3А, Жаргалант сум	353,250,000	Орон нутгийн төсөв, Жаргалант сумын хөрөнгө оруулалт
6	Орон сууцны болон гэр хорооллын гудамжинд гэрэлтүүлэг хийх (15 ажил)	II-III улирал	Х3А, ХББ3А, Баян- Өндөр, Жаргалант сум	2,250,185,500	Орон нутгийн төсөв, Баян-Өндөр, Жаргалант сумдын хөрөнгө оруулалт
7	Хатуу хучилттай болон шороон замын засварын ажлыг үргэлжлүүлэн хийх, аваар осол гарч болзошгүй газруудад толь тавих, туузан хашлага хийх, хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийх (15 ажил)	II-III улирал	Х3А, ХББ3А, Баян- Өндөр, Жаргалант сум	5,653,089,500	Орон нутгийн төсөв, Баян-Өндөр, Жаргалант сумдын хөрөнгө оруулалт

8	Улсын болон орон нутгийн чанартай авто замын хальтиргаа гулгаанаас хамгаалах зорилгоор хайрга, давс, бодис, машин механизмдын шатах тослох, материал, тусгай шингэн хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх, шуурхай алба ажлуулах	II-III улирал	Хот тохижуулах газар	150,000,000	Орон нутгийн төсөв-150 сая төгрөг Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй
9	A1001, A1002 улсын чанартай авто замын аюулгүй байдлыг хангах зорилгоор эвдрэл үүссэн хэсгийг засварлаж, нөхөөс хийх	II-III улирал	"Орхон Азза" ТӨХК	210,000,000	Улсын төсвийн хөрөнгөөр
10	Хотын доторхи авто замын нөхөөс, хөвөөний засвар	I-IV улирал	ХЗА, ХББЗА, Хот тохижуулах газар "Орхон Азза" ТӨХК	500,000,000	Орон нутгийн төсөв
11	Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах. Нам даралтын зуухаар халдаг сургууль, цэцэрлэгүүдийн халаалтын шугам сүлжээний бэлэн байдлыг хангаж он дуустал нүүрс татан авалт, нөөцлөх ажлыг зохион байгуулах.	III-IV улирал	ХЗА, СТСХ, БШУГ	105,900,000	Орон нутгийн төсөв
Нийт					16,399,971,900
Тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, өөрийн хөрөнгөөр хийх ажил					
12	Зуух №3, Турбин №1-ийн их засварын ажил	II-III-р улирал	"ЭДЦС" ТӨХК	2,260,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
13	Үнсэн сан №1-ийн үнсийг хоосолж, даланг өндөрлөх ажил	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	5,992,251,720	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
14	Их засвар, ТЭБАХ, ХО-ийн төлөвлөгөөт ажлыг график хугацаанд хийж гүйцэтгэх	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	10,735,100,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
15	Дуб00мм-ийн ил шугамын дулаалга, ПВ-30 ПВД №1-ийн зүрхэвчийг солих, Дэнж багийн ТК-1/8 худгаас сэтгэцийн эмнэлэг хүртэл 2Ду80, 2Ду100, 2Ду150мм-ийн шугамыг нэгтгэн 2Ду100мм-ийн шугамаар шинэчлэн солих	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	554,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
16	Орхон аймгийн төв Баян-Өндөр сумын 6/0.4кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил	II-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК, Ричвелл инженеринг ХХК	12,790,000,000	Дэлхийн банкны санхүүжилтаар

17	Эрдэнэ багт 35кВ-ын нэг хэлхээт төмөр бетон тулгууртай ЦДАШ барих	II-III улирал	"ЭБЦТС" ТӨХК	370,919,500	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
18	6/0.4 кВ-ын дэд станцууд их засвар болон гадна 6кВ-ын кабель шинэчлэх, АТП-296.279 дэд станцуудын 6кВ-ын ЦДАШ-ын трасс өөрчлөх, РП-204 дэд станцын ячейк-19-н гаргалгааны тосон таслуурыг вакуум таслуураар солих, реле хамгаалалтыг микро процессорын хамгаалалтанд шилжүүлэх	II-III улирал	"ЭБЦТС" ТӨХК	226,350,700	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
19	Эрчим хорооллын гадна цахилгаан хангамж, Эрдэнэ багийн 6/0.4кВ-ын АТП-10 дэд станцын урд хэсэгт 0.4/6 кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын дэд станц барих	III-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК	74,768,400	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
20	Орхон аймгийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх (35кВ-ын Тойрог схем үүсгэх) ТЭЗУ боловсруулах	III-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК	114,400,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
21	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК 2022 оны 10 дугаар сарын 1-ний дотор 20'000 тонн нүүрс нөөцлөх.	1/Х-ний дотор	"ЭДЦС" ТӨХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
22	Орон сууцны байр хоорондын гадна цэвэр усны шугамын засвар, Гэр хорооллын ус түгээх байрнуудын урсгал засварын ажлуудыг хийх гадна тохижилт гэрэлтүүлгийн кабель засварлах шинэчлэх ажил	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХК	147,790,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
23	Ус, дулаан хуваариллах төвүүдэд шаардлагатай халаалт, хэрэглээний халуун хүйтэн усны насосууд болон хаалтууд шинэчлэх. Цахилгааны шитнүүдэд урсгал засвар хийх, ялтсан бойлер шинэчлэх, хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулах, барилгын дээвэр, гадна ханыг будах, гадна оруулгын шугам сүлжээг шинэчлэх ажил	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХК	158,500,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
24	Орон сууцны 75ш байрнуудын цахилгааны ерөө, шитний урсгал засвар, 88ш дэд станцын урсгал засварын ажил. Хотын доторх хаалттай дэд станцуудын дээвэр хаалга засварлах	I-IV улирал	"ЭУДТС" ОНӨХК	53,590,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар

25	Хотын доторх гэмтэлтэй бохир усны шугамыг хэсэгчилэн шинэчлэх, орон сууцны подвальный бохир усны шугамыг шинэчлэх, Танил захын урд талын КНС-д тунгаах худаг, бөмбөлгөн хаалт, Бохирын насос суурилуулах	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХ	50,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
26	Нийтийн орон сууцны байрнуудын оронд вакум цонх хийх, соронзон цоожтой хаалга хийх, дээвэр засвар хэсэгчилж хийх, давхар дундын цахилгааны шитний засварын ажил, орчны засварын ажил, подвальный ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьж устгалын ажлыг хийх	II-IV улирал	Сууц өмчлөгчдийн холбоод, Баян-Өндөр, Жаргалант сум	350,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
27	Цэвэр ус хангамжийн 3 дугаар шугамын дүүргэлт, ариутгал, угаалга хийлгэж ашиглалтанд оруулах	II-III улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
28	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн залгалт, горим тохируулгын ажлыг гүйцэтгэж, түлш үйлдвэрлэх	II-IV улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
29	Халаалтын улирал эхэлхээс өмнө орон нутгийн өмчийн барилга болон сургууль, цэцэрлэгийн цонх, хаалгыг дулаалах, заадас, хаяавч засварлах, Дулааны үзель болон халаалтын шугамыг угаах засварлах.	II-III улирал	Орон нутгийн өмчийн газар, Нийтлэг үйлчилгээний алба, БШУГазар, Сургууль, цэцэрлэгийн захиргаа.	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
30	Баян-Өндөр, Жаргалант сумдын гэр хорооллын айл өрхүүдийн түлшний модоор хангах ажлыг зохион байгуулах	II-III улирал	БОАЖГ, ХОХБТХ Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
31	Орон сууцны болон гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангах	Тогтмол	ХЗА, Баян-Өндөр сум, "ЭУДТС" ОНӨХ	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах

32	Дулааны төв шугамын нягтын туршилтыг гаргасан программын дагуу 2 удаа хийж гарсан гэмтлийг бүрэн засварлах, шаардлагатай тоног төхөөрөмж, шугам сүлжээний засварын ажлыг бүрэн зогсолтын үед хийж гүйцэтгэх	II-III улирал	ХЗА "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Сууц өмчлөгчдийн холбоод	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
33	Өнгөрсөн жилийн халаалтын улиралд ихээхэн гомдол ирсэн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудаар үзлэг шалгалт хийх, илэрсэн зөрчил, доголдлыг арилгах	II-III улирал	ХЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
34	Зөвшөөрөлгүй дулааны холболт хийсэн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудад хамтарсан үзлэг шалгалт хийж, халаалтын горим алдагдуулж байгаа газруудын хэвийн ажиллагааг хангуулах	II-III улирал	ХЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, ГХБХБГ, Баян-Өндөр сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
35	Халаалтын улиралд бэлдэж хотын инженерийн шугам сүлжээнд горимын үзлэг шалгалт хийж дамжуулах болон түгээх шугам сүлжээний дулааны алдагдал шалгах, орон сууцны байрнуудын дулааны уzelьд шайб саппоны тохируулга хийх, ус дулаан хувиарлах төвүүдийн тоног төхөөрөмж, дулаан солилцооны найдвартай ажиллагааг хангах	III улирал	"ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
36	Тухайн байгууллага өөрийн харъяа инженерийн байгууламж, шугам сүлжээнд доголдол, гэмтэл гарсан тохиолдолд хэрэглэх сэлбэг материал, тоног төхөөрөмж, машин механизмын бэлэн байдлыг хангах	I-IV улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "ЭБЦТС" ТӨХК, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, "МХС" ХХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
37	Үерийн усны далан сүвгийг бүрэн цэвэрлэх, улирал бүр үзлэг шалгалтыг хийж сүвгийг сэргээн хэвийн ажиллагааг хангаж ажиллах	Улирал бүр	ХЗА, Баян-Өндөр, Жаргалант сум, Онцгой байдлын газар, Хот тохижуулах газар	-	Байгууллагууд хамтарч ажиллах

38	Гэр хорооллын болон орон сууцны хорооллын борооны ус зайлуулах суваг, халаалт, цэвэр, бохир ус, холбооны худгуудыг цэвэрлэх, лайдах засвар үйлчилгээ хийж, худгуудын тагны бүрэн бүтэн байдлыг хангах	II-III улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Хот тохижуулах газар, "МХС" ХХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
39	Аймгийн хэмжээнд цахилгаан, холбооны агаараар татагдсан инженерийн шугам сүлжээнд үзлэг хийж унжилт ихтэй шугамыг татах, илэрсэн зөрчлүүдийг арилгах	II-III улирал	Хотын захирагчийн алба, "ЭБЦТС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, "МХС" ХХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
40	Хэрэглэгчид эрчим хүчийг хэмнэх, орон байрны дулаан алдагдлыг бууруулах талаар мэргэжлийн заавар, зөвлөгөө зөвлөмж өгөх	I-IV улирал	"ЭДЦС" ТӨХК, "ЭБЦТС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Хэвлэл мэдээллийн алба	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
41	Хот хооронд болон аймаг хооронд зорчигч тээврийн үйлчилгээнд гарч буй тээврийн хэрэгслүүдийн бэлэн байдлыг хангуулах, үзлэг шалгалтыг эрчимжүүлж, "Тээвэрлэгч бид өвөлд бэлэн" өдөрлөгийг зохион байгуулах	III-IV улирал	Авто тээврийн төв	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
42	Хотын нийтийн тээврийн автобусанд парк шинэчлэлт хийх (Хувийн хэвшлийн оролцоотой)	I-IV улирал	Аймгийн ЗДТГ, Авто тээврийн төв	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
43	Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад шуурхай мэдээлж ажиллах	Тогтмол	Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
Нийт					33,877,670,320

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны
05 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит IX хуралдааны
09/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ОРХОН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2022-2023 ОНЫ
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллага	Төсөвт өртөг /сая.төг/	Хөрөнгийн эх үүсвэр
Нэг: Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар:					
1.	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөг батлуулж, биелэлтэд хяналт тавих, дүн мэдээг ХХААХҮЯ-нд хүргүүлэх	I-II улиралд	ХБТХОХ, ХХААГ, Сумдын ЗДТГ	-	-
2.	Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах /ЗГ-ын тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэх/	III-IV улиралд	ХХААГ, ХХҮГ, ОБГ, Сумдын Засаг дарга нар	70.0	ОНТ
3.	Өвөлжөө, хаваржааны тодорхой бүс нутаг, таримал ургамлын талбайг малаас хамгаалах, чөлөөлөх ажлыг зохион байгуулах	II-III улиралд	Жаргалант сумын ЗДТГ	-	ОНТ
4.	Малчин, мал бүхий иргэнээр байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх	III улиралд	Сумдын ЗДТГ, Малчин баг, мал бүхий багууд	-	-
5.	Хадланчдад талбай олгуулах, мал өвөлжүүлж, хаваржуулах, нутаг бэлчээр ашиглуулах асуудлаар хил залгаа аймаг, сумуудтай хамтарч ажиллах	II-III улиралд	ХХААГ, Сумдын Засаг дарга нар	-	ОНТ
6.	Малчин өрх малын хашаа байраа сэлбэн засах, түлээ, түлш, өтөг бууц нөөцлөх, хөрзөн гаргах, сийрүүлэх арга хэмжээ авах	II-III улиралд	Сумдын ЗДТГ, багийн Засаг дарга нар	-	-
7.	Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг шуурхай гаргаж, мэдээллийг мал ахуй эрхлэгчдэд шуурхай хүргэх	Тухай бүр	УЦУОШТөв, ХХААГ, Сумдын Засаг дарга нар	-	-

8.	Зуншлагын цагийн байдалтай танилцаж, үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах	III улиралд	УЦУОШТөв, ХХААГ, Сумдын Засаг дарга нар	-	ОНТ
9.	Өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тохируулан сум, багаар нэгтгэн гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулах, орон нутагтаа болон отроор өвөлжиж, хаваржих малчид болон малын судалгааг нарийвчлан гаргах	III улиралд	ХХААГ, Сумдын ЗДТГ	-	-
10.	Малыг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтанд бүрэн хамруулах ажлыг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулах, ажлын үр дүн, тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлэх	II-IV улиралд	ХХААГ, Сумдын ЗДТГ	8.0	ОНТ
11.	Бэлчээрийн худаг уст цэгийн бэлэн байдлыг хангах, шинээр гаргах буюу засварлах ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх	II-IV улиралд	ХХААГ, Жаргалант сумын Засаг дарга	130.0	УТ, Жаргалант сумын ОНТ
12.	Цаг агаарын байдал хүндэрсэн тохиолдолд малчдад хүнс, өвс тэжээл хүргэх, даваа, гүвээ засах цас ярагч техник хэрэгсэл, туулах чадвартай машины бэлэн байдлыг хангах	I, IV улиралд	ХБТХОХ, ХХААГ, Сумдын ЗДТГ	-	ОНТ
13.	Малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулах	III улиралд	ХХААГ, сум, багийн Засаг дарга нар	-	ОНТ

Хоёр: Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр:

14.	Аймгийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний цэгүүдэд худалдаалагдаж буй мах, махан бүтээгдэхүүн, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх хүнсний болон мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд хүнсний аюулгүй байдлын шинжилгээ хийж үр дүнг олон нийтэд танилцуулах	Тухай бүр	МЭГ-ын Мал эмнэлгийн лаборатори, ААН-үүд	8.5	УТ
15.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 11.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 2-р хавсралтад заасан 4 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үнэ, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсөвт тусгуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	II-IV улиралд	Аймгийн ЗДТГ-ын СТСХ, МЭГ, МЭ-ийн Тасаг, МЭУ-ийн нэгж	38.06	ОНТ

16.	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт шинжилгээ хийх (шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах)	II-III улиралд	МЭГ, УМЭАЦТЛ МЭ-ийн лаборатори	3.2	УТ
17.	Мал, амьтны сэг, зэм устгах, малчдын өвөлжөө, хаваржааг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах	II-IV улиралд	МЭГ, Сумдын ЗДТГ	12.2	ОНТ
Гурав.Газар тариалангийн бэлтгэл хангах талаар:					
18.	Тариалалт, уринш боловсруулалтын ажлыг технологийн зохистой хугацаанд чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх	I, II улиралд	ХХААГ	2.2	ОНТ
19.	Бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх, таримлын зөв сэлгээг нэвтрүүлэх замаар хөрсний уржил шимийг хамгаалах	I, II улиралд	ХХААГ, МХГ, Сумдын ЗДТГ	-	-
20.	Ургац хураалтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, шуурхай зохион байгуулах, аж ахуйн нэгж, айл, өрх, иргэдийн хураан авсан үр тариа, темс, хүнсний ногоо, жимс, жимсгэний ургацын мэдээг үнэн зөв шуурхай гарган холбогдох газруудад танилцуулан тайлан мэдээг хүргүүлэх	III, IV улиралд	ХХААГ, Сумдын ЗДТ	2.3	ОНТ
21.	Намрын ургац хураалтын ажилд шаардагдах шатахууны нөөцийг бүрдүүлэх, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах арга хэмжээ авч ажиллах	III улиралд	ХХААГ, "ЭБЦТС" ТӨХК	-	-
22.	Ургац тээвэрт ашиглагдах зам гүүрийн эвдрэл, гэмтлийг шалгаж тодруулах, шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж эх үүсвэрийг нь шийдвэрлүүлэн засварын ажлыг шуурхайлах, төмөр замаар тээвэрлэгдэх ургац тээвэрлэлтэд саатал гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах	III улиралд	ХЗА	-	-
23.	Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийж дуусгах, дараа оны тариалалтад нөөцлөх үрийн цэвэрлэгээг шалгаж стандартад тэнцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж ажиллах	III улиралд	МХГ, ХХААГ	-	-
24.	Намрын ургацаас чанар сайтай үрийн болон хүнсний буудайн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, нөөцийн агуулах, элеваторын бэлэн байдлыг хангах	III, IV улиралд	ХХААГ, МХГ, ОБГ Сумдын ЗДТГ	-	-
25.	Ургац хураалтын үед ашиглагдах жин хэмжүүр, хэмжих хэрэгсэлийн баталгаажуулалтыг хийх	III улиралд	СХЗХ	-	-

26.	Ургац хураалтын явцад тариаланчдыг цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр тогтмол хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	I, II, III улиралд	УЦУОШТөв, ХХААГ Сумдын Засаг дарга нар	-	-
27.	Ургац хураалтын ажилд оюутан, цэргийн албан хаагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулах, тэдгээрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах	III улиралд	ХХААГ, ЦШ, БСУГ, ХХҮГ	-	-
28.	Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд мал бүхий иргэдийг буулгахгүй, малыг хариуллага, маллагаатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	II, III улиралд	Сумдын ЗДТГ, ЦГ	-	-
29.	Ургац хураалтын ажлын явц болон үр дүнг олон нийтэд хүргэх, тариалангийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг сурталчилах чиглэлээр хамтран ажиллах	III, IV улиралд	ХХААГ, Сумдын ЗДТГ	-	-
30.	Үр тариа, темс, хүнс ногооны тээврийг саадгүй нэвтрүүлэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай зам, гүүрэн дээр цагдаагийн эргүүл пост ажиллуулах	III улиралд	ЗЦТ	-	-
31.	Темс, хүнсний ногооны борлуулалтыг дэмжих, орон нутгийн иргэдийг хямд үнэтэй, чанартай ногоогоор хангах зорилгоор темс, хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	III улиралд	ХХААГ, Сумдын ЗДТГ	2.0	ОНТ
Гурав. Хүнсний чиглэлээр:					
32.	Хүн амын хаврын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлж ажиллах	I, II, IV улиралд	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ХХААГ	600.0	ОНТ